

ЭРТНИЙ МОНГОЛ ЯТГЫН ТУХАЙД

Л.Хэрлэн

Түлхүүр үг: Монголын хөгжмийн түүхийн эх сурвалж, баримтууд дахь эртний хөгжмийн зэмсгийг сэргээн бүтээх, баримтжуулах тухай

Эртний Буддын түүхэнд босоо ятгын тухай: Сидхарда буюу бурхан Будда нь өөрийн эцгийн өргөөнд уянгалаг аялгуу сонсох дуртай байсан бөгөөд түүнд нь босоо ятга биба, хөндлөн бишгүүр болон бөмбөрийг хамтатгаж найрал хөгжим болгон сонсдог байжээ. Үүний дундаас хэвтээ ятга болон босоо ятга хоёрыг хамтад нь сонсох дуртайгаас улбаалаад буддын хөгжим бол босоо ятга буюу конгхоу болсон байдаг байна. Эртний Дунхуоны агуйн хананд үүний талаар маш тодорхой бичээстэй байдаг. Босоо ятгыг 4 хэлбэр болгон хуваасан бөгөөд *нум сум, өнцөгт хэлбэр, очирт, сүм* хэлбэртэй гэж. Хамгийн анхны *нум сум хэлбэрт ятга* нь МЭӨ 1900-2900 оны үеийн Иран, Иракаас гаралтай бол *өнцөгт хэлбэрийн ятгыг* өмнөд Ази болон Египетээс гаралтай. Нум хэлбэрийн ятга нь Энэтхэг болон Индусийн нийгэмтэй холбоотой. Ийнхүү нум хэлбэрт болоод өнцөгт ятга нь Егитэд болон Хятадын ятгын хэлбэр төрхийг тодорхойлж иржээ.

Торгоны зам нээгдэхэд Энэтхэгийн *нум хэлбэрт босоо ятга* нь Иран хүртэл дэлгэрэнгүйгээр хөгжиж ерөнхийдөө баруун зүг болон өрнөдөд дэлгэрсэн. Торгоны зам нь нуман босоо ятгыг хөгжүүлэх гол хөшүүрэг нь болсон байна. Дунхуоны агуйн ханын зурагт Хятадын нуман ятга Энэтхэгийн нуман ятгуудын хэлбэрийг тодорхой гаргаж өгснөөрөө түүхийн бичээст хадгалагдан үлджээ. *Өнцөгт ятганы түүх* нь будда болон Хятадаас гаралтай гэж үздэг бөгөөд МЭ 581-907 онд Сүй болон Тан гүрний ордны эмэгтэй хөгжмийн зэмсэгчдээс гаралтай гэж үздэг. Тан гүрний үед уран зохиол, урлаг маш эрчимтэй хөгжсөн бөгөөд үүний нэг шалтгаан нь тэр үеийн Чанган тосгоны байгалийн өвөрмөц байдал нь энэхүү хөгжмийг үүсгэсэн хэмээн холбон тайлбарлагддаг. Намрын борооны улирлаар өнгө өнгийн солонго татсан нь босоо ятганы чавхдасыг санагдуулан, борооны дуслын чимээ, гол усны харгиа усны чимээ нь хөгжмийн ая аялгууг бий болгоход, загас уснаас тэнгэрт үсэрч өнцөг үүсгэх үйлдэл нь өнцөгт ятгыг хийх санааг төрүүлж бүтээгдсэн гэжээ. *Очир хэлбэрт ятга* нь МЭ 1000 оноос үүсэлтэй бөгөөд Хятад болон Японоос гарал үүсэлтэй гэж үздэг. Очир ятгын нэг жишээ нь Дунхуоны агуй болон Японы Коясан музейд хадгалагдан үлдсэн байна. Энэ ятганы хэлбэр нь хоорондоо ижил хэлбэртэй байсан гэж Шинжианы археологчид тэмдэглэн үлдээжээ. Очирт ятга нь буддагийн үеийн титэмийн хэлбэртэй, орой хэсэгтээ очирт хийсэн байдаг нь энэ ятгын үүсэл гэж үздэг. Японы буддын түүхэнд буддын дурсгалд зориулж түүний диваажин болоод гэгээрлийг сэтгэлдээ бодож аялгууг нь гаргахыг эрмэлзэж очир ятгыг түүнтэй адилтгаж хийсэн хэмээдэг байна. Үүнтэй адилхан маш олон хувилбарт түүхүүд байдаг бөгөөд үүний нэг жишээ нь “Коёосан” дуурьт энэ тухай дурдаж дуулдаг.



ОХУ-ын Санкт-Петербургийн
Эрмитажийн музейд хадаглагдаж
буй ятга

Өөр нэг жишээ нь Монголын эртний Хархотод цөөхүүл хөгжимд хөгжимдөж байсан нуман төрлийн босоо ятга ба энэ нь Хятадын Чинян гүрний очир хөгжмийн зэмсэгтэй тун төстэй бөгөөд хамгийн анх МЭӨ 1000-1200 оны Монголын Хархотод үүссэн гэж үздэг ба нэг олдвор Оросын Санкт-Петербургийн Эрмитажийн музейд хадгалагдаж байна (зураг №1).

Очирт ятгын том жишээг Дунхуаны музейгээс харж болно. Сүмт ятгын жишээ нь Евразийн сүмүүдээс гаралтай гэж үздэг бөгөөд хамгийн анхны хувилбар нь МЭӨ 650-850 оны Ассирын дурсгал болон МЭӨ 1900 оны Месопотамын дурсгалуудад Хятадын Шинжианаас торгоны замаар дамжин орж ирсэн гэж тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

“Ерөнхийдөө торгоны замд үлдсэн 5 төрлийн босоо ятга байдаг байсан гэж тэмдэглэгдсэн ч Ассирын босоо ятганы дүр зураг устаж үгүй болжээ. Алтайн нуруу болон Сибирийн нуруугаар босоо ятганы түүх дурсгалууд үлдсэн байдгаас Ассирийн босоо ятга нь 9 утастай өнцөгт босоо ятга байсан хэдий ч Евро Азийн хүмүүс энэ ятгаар ятгаддаг байжээ. Сүмт босоо ятга нь буддын шашны нэгэн үлдэц хэмээн тэмдэглэгджээ. Эртний Дунхуаны агуйн археологийн зурагт босоо ятгыг Энэтхэг, Япон, Монгол гэсэн 4 үндэстэн тоглодог байсан бөгөөд МЭӨ 1000 оноос гаралтай гэж үзээд энэ 4 төрлийн ятгын уг үндэс нь Конгхоу хөгжмийн зэмсэг хэмээн тэмдэглэгдэн үлдсэн нь одоогийн хятадын түүхэнд л бичигдэж хадгалагдсан байна (Neville Agnew, 2010:118).

Монгол өнцөгт болоод нумт ятгын талаар олон эрдэмтэд үүсэл, түүх, нэр гарвалыг ийнхүү тодорхойлсон байна. Тухайлбал, Доктор Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” хэмээх номондоо а.т.ө. 119 онд Хятадын цэрэг Хүннүгийн зүүн цэцэн вангийн туг, хүүргийг (хэнгэргийг) олзлон авсан тухай хятад сурвалжийн мэдээнээс эш татан өгүүлсэн байдаг. 198 онд холбогдох “Хоу Ханшү” буюу “Зүүн Хан улсын бичиг”-т Фан Е бичихдээ: “Лин-Ди хаан хүннү хувцас, хүннү сууц, хүннү ор, хүннү исэр, хүннү кун-хэ-ү, хүннү бишгүүр, хүннү бүжигт дуртай байв” гэжээ. Дээр дурдсан хөгжмийн зэмсгүүдийн талаар олон эрдэмтэн, судлаач Азийн орнуудын түрэг, хүннү түүх соёлын сурвалж хэрэглэгдэхүүн дээр үндэслэн харьцуулсан судалгаа хийсэн байдаг.

Хун-хэ-у-ийн талаар Францын дорно дахины судлагч Поль Пеллио, Шотландын Глазгогийн их сургуулийн хөгжим судлаач Хенри Фаме, Монголын түүхч Гажидын Бадрах, хөгжим судлаач Жамцын Бадраа, Японы хөгжим судлаач Токтогийн их сургуулийн профессор Шигео Кашибе, Кембреджийн их сургуулийн доктор Лоренс Пиккен зэрэг олон эрдэмтэд хун-хэ-у-г монгол түрэг гаралтай хөгжим бөгөөд Ху нар буюу Хүннү нарын хөгжим, хун ба хүн хуур, хун толгойтой хуур хөгжим, хун-хэ-у буюу босоо ятга гэж тодорхойлжээ.

Поль Пеллио хун-хэ-у-г хуур, хобустай холбож тайлбарласан бол Кишибе хэд хэдэн баримт бичиг, Японы эрдэмтдийн судалгааг үндэслэн 1954 онд “Хун-хэ-у”-гийн үүсэл буюу босоо ятгын үүсэл” хэмээх эрдэм шинжилгээний нилээд сонирхолтой тусгай өгүүлэлдээ босоо ятгын нэгэн төрөл гэж бичсэн байдаг.

Анкарагийн Их сургуулийн профессор байсан Еберхард энэ мэдээг “нэн сонирхолтой баримт” гэж үзээд “кун-хэ-у хөгжмийг ямар ч атугай эрт дээр үеэс Хүннү нар хэрэглэж байсан

нь тодорхой бөгөөд дараа нь Солонгос, Япон зэрэгт түгэн тархаж дорно дахины улс түмэнд бие биеэсээ дамжуулан хэрэглэх болсон зам мөрийн эхийг тавьсан” гэдэг билээ.

Дээрх өгүүлэлд Монголын түүхч Г.Бадрах, хэл шинжээч, хөгжим судлаач Ж.Бадраа нар: “Өрнө дорнын олон эрдэмтэд энэхүү хун-хэ-у хөгжмийг тайлбарлах гэж оролдож байгаа ч гэсэн Монголын ард түмний газар зүй, түүхэн хамаарлыг гэд цаг ямагт тойрч ирсэн дээрээс бодит тайлбар өгч чадахгүй байгаа юм” гээд “хун-хэ-у гэдэг нь харьцуулсан хэл шинжлэл, түүх, угсаартны, хөгжим судлалын задлан шинжилгээний үндсээс тайлбарлавал энэ үг нь монгол үг мөн бөгөөд кун буюу хун шувууны хун, хэ гэдэг нь хуур гэсэн үг, өөрөөр хэлбэл “хун толгойтой хуур” юм гэсэн дүгнэлтийг өгчээ.

Эртний Монголын Хүннү нарыг “Ху” нар хэмээн нэрлэж байсан ба энэхүү “ху” гэдэг үг, ханз үгсийн цаана Хүннү нартай холбоо бүхий арав гаруй утга бүхий ойлголт агуулагдаж байгааг доктор Я.Ганбаатар тайлбарласан нь ч бий. Кунхоу гэдэг нь 1. Босоо ба хөндлөн хоёр янз байсан, 2. Хоёр гараар товших зэмсэг эсвэл тусгай нумаар хөрөөдөжд уугаргадаг нэгэнз үйл чавхдаст хөгжмийн зэмсэг байсан гэдэг нь одоо тодорхой болжээ (Хэрлэн, 2006:13-15).


Хүннү нарын хэрэглэж байсан хун-хэ-у нь (эрдэмтдийн тайлбарласнаар хун-хэ-у нь Ху нар буюу Хүннү нарын хөгжим, хун ба хүн хуур, хун толгойтой хуур хөгжим, хун-хэ-у буюу босоо ятга) хөрш зэргэлдээ Хятадаар дамжин зүүн өмнөд Азид дэлгэрч, өрнөдөд дундад Ази, Оросоор дамжин Европод түгэн тархаж байсан гэсэн Ебархардын тэмдэглэлээс цөөн бус судлаач энэ саналтай нэг байдаг. Тухайлбал Оросын эрдэмтэн Д.В.Яровой, францын хөгжим судлаач Г.Гельмгольц, Г.Фестиль нар эртний Грек, Европ, Африкийн вилиотто, лира, кассир утсан хөгжмүүд нь Азийн таван утастай, таван хөгтэй хөгжмөөс гаралтай гэснээс үзвэл Монголын босоо ятга нөлөөлсөн гэх үндэслэл гаргаж болох байна. Мөн Бээжин хотын хөгжим судлалын газрын Шангол орны алдарт ятгачин Шан-ган-ши “Хамтарсан дуу хөгжим” сэтгүүлд нийтлүүлсэн “Ятга судлалын тухай” өгүүлэлдээ “Чин улсын ятга хөгжим нь агуу ятгаас хувирч өөрчлөгдөн ирсэн ба хамгийн эртний ятга бол хулсан бүтэцтэй, гурван тохой илүү урт, хэдхэн ямх өргөн тул мөрлөн авч явахад тун дөхөм байсан” гээд “...нарийвчлан судалбаас ятгыг хамгийн түрүүнд дуу хуурт дуртай нүүдэлчин, малчид урлан бүтээсэн нь магад, энэхүү хөгжмийг Хатан голын ар буюу баруун талаар нүүдэллэх цөөн хэдэн үндэстний бүтээсэн хөгжим” хэмээн тайлбарласан байна. Хятадын судар бичгүүдэд “хун-хэ-у-г морин дээр хөгжимдөх бөлгөө” гэснээс үзвэл босоо ятгын нилээд эртний хэлбэр монголчуудын дунд эрт үед хэрэглэгдэж байсныг тодруулж болно.

Монголчуудын дунд ятгын анхны өвөг болох “хун толгойтой хуур” болох хун-хэ-у хөгжмийн нэгэн төрөл босоо ятга Грекээр дамжин Европт дэлгэрэн, өрнийн эртний хөгжмийн зэмсэг хэмээн нэрлэгддэг лир хөгжим түүний хэлбэр дүрс хөгжмийн урлагийн онцгой бэлгэ тэмдэг болж хадгалагдан үлдсэнийг ч бас анхаарч үзүүштэй. Өнөөдөр монгол хөгжмийн бэлгэ тэмдэг өөрийн гэсэн үндэсний өнгө төрхтэй хийгдэх цаг нь болсныг бас дурдах нь зүйтэй болов уу. Сүүлд босоо ятгын талаар Юан улсын түүхийн тэмдэглэлд Хубилай хааны их ордонд төрийн ёслолын үйл ажиллагаанд 24 утастай эргэвч (тулгуур)-тай модоор хийсэн баганын үзүүрт гарьдын толгойтой босоо ятга хэрэглэж байсан тухай тэмдэглэсэн байна.

Босоо ятгын нэгэн төрөл нумлиг болон өнцөгт босоо ятгын талаар: Цуурайн хайрцаг буюу хэвлий, чавхдас татах багана хоёрын нь хооронд нум мэт дугуй матаас гарсан нь нумлиг босоо ятга, цуурайн хайрцаг буюу хэвлий, чавхдас татах багана хоёрын нь уулзварт дугуй бус өнцөгтэй матаас гарсан нь өнцөгт босоо ятга бөгөөд нэн эртний босоо ятгын язгуур хоёр хэлбэр ажээ” хэмээн монгол босоо ятгын тухай түүхнээ босоо ятгын сурвалж судлалыг Б.Содном, Ж.Бадраа нарын тэмдэглэлд бий.

Энэ ятгын нэгэн төрөл болох археологийн олдвор олдсон нь түүхэн мэдээ баримт сурвалжийг биетээр нотлох баримт болсон билээ. 2008 онд Ховд аймгийн Манхан сумын Жаргалантхайрхан уулын хадны хагалбарт хийсэн булшны судалгаагаар эртний нүүдэлчдийн нэн ховор хөгжмийн зэмсэг “босоо ятга” хөгжим олдсон нь соёлын өв судлал төдийгүй хөгжим судлалын томоохон нээлт болсон юм.

Жаргалантхайрханы оршуулганд хүний толгойг зүүн хойд зүгт хандуулж нуруугаар нь хэвтүүлэн хоёр гарыг их биеийг дагуулан чигээр нь сунгаж хоёр хөлийг нь нийлүүлэн жийлгэж тэнэгэр байдлаар тавьжээ. Талийгаачийн толгой харалдаа хойд талд нь модоор хийсэн нэгэн хөгжмийн зэмсгийг царыг нь дээш харуулан толгойг нь зүүн зүгт хандуулан тавьсан байна.




Булшан дахь хүний толгойн зүүн хойд хэсэгт байрлаж байгаа хөгжмийн зэмсгийн схем зураг

Энэхүү хөгжмийн талаар судлаачид үүсэл гарвалын хувьд VII зуунд хамааруулан үзэж байгаа бөгөөд хөгжмийн эх олдворыг Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн судлаач доктор Ц.Төрбат, Д.Батсүх, Т.Батбаяр нарын нээлтийн үр дүнд олонд танилцуулж, хэлбэр бүтэцийнхээ хувьд монголчуудын эртний хөгжмийн зэмсэг хэмээн тодорхойлж байна.



Хөгжмийн ерөнхий байдал, Монголын үндэсний музейд хадгалагдаж байгаа эх олдворын зураг

Хөгжмийн доод тал дээр хадны зурган дахь дүрслэлийн аргаар нэгэн анчин эр элдэв ан амьтныг агнаж буй зохиомжит зургийг битүү сийлжээ.



Хөгжмийн ишэн дээр эртний руни бичгээр бичсэн бичээсийг хэд хэдэн эрдэмтэн тайлан уншжээ.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
᠑	ᠠ	ᠴ	ᠯ	ᠮ	ᠮ	ᠯ	ᠰ	ᠬ	ᠬ	ᠰ	ᠴ
y ^e	p	z	č	ö	r	a	nt	t ²	d ²	m	z




12 11 10 9 8 7 6 5 4 3 2 1

Хөгжим дээрх руни бичгийг галиглан бичсэн байдал


"Питер Зимэ судалгаандаа уг бичээсийг: **y(e)p(.)z čör ant (e)td(i)m(i)z- y(e)p(.)z and čör we swore an oath (Lit, we made in oath) – Йепиз ба Чөр, бид анд болжухуй** гэж орчуулжээ.

Б.Напыл **Yinčüre bitidimiz** хэмээн галиглаад **Хүндэтгэн бичвэй (бид)** гэсэн утгатай гэж үзжээ. Харин МУИС-ийн багш, түрэг судлаач Ц.Баттулга тайлбартаа: **zm}twaRucMPJ** буюу галигчлан орчуулбал **yepin čöra bitdimiz** буюу "Йепин-чурт бичив" гэсэн утгатай" (Баттулга, 2012) хэмээн үзсэн байна.

Уг хөгжмийг Герман-Монголын хамтарсан судалгаагаар дахин сэргээж нутагшуулах арга хэмжээ олон жилийн судлагааны үр дүнд 2014 онд нээлтээ хийж олонд танилцуулсан билээ.



Германы судлаачдын сэргээсэн загвар



Д.Ганпүрэв, П.Байгалжав нарын сэргээн урласан загвар

Германы судлаачдын сэргээж шинчэлсэн нэг загвар, нөгөө нэг загварыг Д.Ганпүрэв 2011-2013 оны хооронд судалж хөгжмийн дутуу эд ангийг гүйцээж, үйлдвэрлэлийн нарийн хэмжээст зургийг гаргаж, уламжлалыг сэргээх, язгуур урлагийн хэрэглээнд оруулах зорилгоор хөгжим урлаач П.Байгалжавтай урлан олонд таниулж “Алтай ятга” хэмээн нэрлэж амжилттай нутагшуулах ажил хийж байна.

Д.Ганпүрэвийн мэдээлснээр гурван төрлийн “Алтай ятга”-г нутагшуулах боломжтой. Тэдгээрийн хөгжимдөх арга барил хөг хөглөгөө, дуугаралт, дуурьслын хувьд өөр хоорондоо ялгаатай бөгөөд зэмсгийн дуугаралтын хувьд 1-цээл, 2-бориг буюу Тэхээ ятга байна. Ирээдүйд хөгжүүлэх Алтайн ятгын бүл зэмсгүүд нь

1. Цээл ятга нь чавхдасын тоо нь 11-13 байна. Гоцлол төрлөөр хөгжимдөхөөс гадна бусад төрлийн ятгуудтайгаа эгшиг хэмнэлээр найрсан дуугарахдаа илүү баялаг дуурьслыг бий болгох боломжтой.
2. Янгир ятга нь чавхдасын тоо 6 байна. Илүү бориг дуутай ихэвчлын хамсран хөгжимдөх зориулалттай. Магтаал туулийн хөгжимд давамгай хэрэглэнэ. Хөөмэйтэй хорших боломжтой хэмээн үзжээ.

Дүгнэлт

Монголын хөгжмийн түүхэнд холбогдох эртний ятгын тухай эдгээр мэдээ баримтууд нь археологийн олдвороор ч баталгаажжээ. Харин энэ мэт түүхнээ судалгаанд тэмдэглэгдсэн монгол хөгжмийн зэмсгүүдийг цаашид бид яаж өвлөн уламжлах асуудалд анхаарлаа хандуулах шаардлага тавигдаж байна. Олон шинжлэх ухааны заагт судалгаа явуулах шаардлага тавигдаж байгаа орчин үед хөгжим судлалын салбар археологийн салбартай хамтран дээрх хөгжимт өв соёлуудыг дахин сэргээж эх нутагт нь нутагшуулах хэрэгтэй байгаа нь ажиглагдаж байна. Иймд урлаг судлалын судалгаанд мэр сэр дурьдагдаж байгаа ховор хөгжмийн зэмсгүүдийн нэр төрөл, хэлбэр загваруудыг тодорхой болгож хөгжмийн зэмсэг урлалын хамтын ажиллагаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх таатай боломж бүрдэж байгааг энд цохон тэмдэглэж байна.

Summary

In Mongolian ancient harp history have been confirmed by the archeological finds. However we will study to the mongolian ancient harp history, it is so special things in mongolia because that is inheritance of the ancient art history. Then we will exploration with archeological division about the mongolian ancient harp history. Therefore it is important and development to art of study in the mongolian ancient instrument history.

Номзүй

Бадраа Ж. *Монгол ардын хөгжим.* Уб., 1989.

Бадрах Г. *Монгол ардын хөгжмийн түүхээс.* Уб., 1966.

Баттулга Ц. *Монгол нутгаас олдсон руни бичигтэй нэгэн хөгжмийн тухай.* Урлахуйн ухааны уламжлал ба орчин үе. Уб., 2012.

Дашдорж Д., Цоодол С. *Ардын дуу хөгжмийн суу билэгтнүүд.* Уб., 1971.

Хэрлэн Л. *Монголын хөгжмийн зэмсгийн түүхээс.* Уб., 2006.

Neville Agnew. *Conservation of Ancient Sites on the Silk Road.* Proceedings of the Second International Conference on the Conservation of Grotto Sites. Mogao Grottoes, Dunhuang, People's Republic of China, June 28 – July 3, 2004. Getty Publications. 2010.